



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС - PMI

2023.II
улирал

2023 оны 8 дугаар сарын 10-ны өдөр

МОНГОЛБАНК

Энэхүү үзүүлэлтийг олон улсад нийтлэг ашиглагддаг аргачлалын дагуу бодлого боловсруулагчид, бизнес эрхлэгчид болон олон нийтийн хэрэгцээнд зориулж улирлын давтамжтай тогтмол гаргаж байна.

1. Худалдан авалтын менежерийн индекс (PMI)

Ерөнхий индекс: Монгол Улсын худалдан авалтын менежерийн ерөнхий индексийн утга 2023 оны II улиралд тэлэлтийн мужид **56.2%**-тай гарлаа. Энэ нь өмнөх улирлаас 1.7 нэгж хувиар өссөн үзүүлэлт болж байна. Өмнөх улирлын үзүүлэлтээс өсөхөд үйлдвэрлэл, бараа материалын нөөц болон шинэ захиалгын индексийн утга өссөн нь голлон нөлөөлөв /Зураг 1-2/.


Нийлмэл индекс: Нийлмэл индексүүдийн хувьд ажил эрхлэлт 8, үйлдвэрлэлийн индекс 5 улирал дараалан тэлэлтийн мужид гарсан бол нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа 10 улирал дараалан агших мужид тус тус гарлаа. Шинэ захиалгын индексийн утга өмнөх улирлаас огцом өсөж тэлэлтийн мужид шилжсэн бол ажил эрхлэлтийн индексийн утга буурч босго утгаас бага зэрэг дээгүүр түвшинд хүрсэн байна. /Зураг 2/.

Салбарын индекс: Энэ улиралд бүх салбарын индекс тэлэх мужид гарлаа. Аж үйлдвэр болон үйлчилгээний салбар тус бүр 5 улирал дараалан тэлэлтийн мужид гарсан бол барилгын салбарын индекс анх удаа тэлэх мужид гарсан байна. Өмнөх улирлын утгатай харьцуулахад барилгын салбарын индекс 9.2, аж үйлдвэрийн салбарын индекс 4.8 нэгж хувиар өссөн бол дотоод худалдааны салбарын индекс 3.1, үйлчилгээний салбарын индекс 1.2 нэгж хувиар тус тус буурлаа /Зураг 3/.


Зураг 1. Ерөнхий индекс



Зураг 2. Нийлмэл индекс



Зураг 3. Ерөнхий индекс, салбараар



Үйлдвэрлэлийн индексийн утгыг бодит ДНБ-ий жилийн өөрчлөлттэй харьцуулан харахад үйлдвэрлэлийн индексийн утга 50%-аас их гарсан дийлэнх үеүдэд бодит ДНБ өсөлттэй гарсан байна. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэлийн индексийн утга нь бодит ДНБ-ий өсөлтийг тайлбарлах чадвар өндөр байна. 2023 оны II улирлын үйлдвэрлэлийн индексийн утга 63.4%-тай гарсан нь тус улиралд бодит ДНБ өмнөх оны мөн үеэс өсөх төлөвтэйг харуулж байна /Зураг 4/.

Зураг 4. Бодит ДНБ-ий улирлын өөрчлөлт болон үйлдвэрлэлийн индекс




2. Салбарын үзүүлэлтүүд

Аж үйлдвэр: Тайлант улиралд салбарын ерөнхий үзүүлэлтүүдийн хувьд ажил эрхлэлт, үйлдвэрлэл, шинэ захиалга болон бараа материалын нөөцийн индексийн утга тэлэлтийн мужид гарсан бол нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны индексийн утга агшилтын мужид гарлаа. Өмнөх улиралтай харьцуулахад шинэ захиалгын индексийн утга өсч тэлэх мужид шилжсэн бол нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа, нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны индексийн утга буурч агших мужид шилжлээ /Зураг 5/.

Нэмэлт үзүүлэлтүүдийн хувьд дуусаагүй үйлдвэрлэлийн индекс өмнөх улирлаас 12.4 нэгж хувиар өссөн бол бүтээгдэхүүний үнийн индексийн утга 16.1 нэгж хувиар буурсан нь гол өөрчлөлт болж байна. Бэлэн бүтээгдэхүүн, худалдан авалтын тоо хэмжээ, түүхий эд материалын үнэ болон бизнесийн үйл ажиллагааны төлөв зэрэг үзүүлэлтүүдийн индексийн утга тэлэх мужид гарсан ч өмнөх улирлаас бага зэрэг буурсан байна /Хүснэгт 1/.

Зураг 5. Аж үйлдвэрийн салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр



Хүснэгт 1. Аж үйлдвэрийн салбарын нэмэлт үзүүлэлтүүд


Үзүүлэлт	2022.IV	2023.I	2023.II
Дуусаагүй үйлдвэрлэл	50.7↓	51.4↑	63.8↑
Бэлэн бүтээгдэхүүн	35.5↓	62.9↑	59.7↓
Бүтээгдэхүүний үнэ	69.4↓	79.5↑	63.4↓
Худалдан авалтын тоо хэмжээ	57.6↓	52.6↓	52.5↓
Түүхий эд, материалын үнэ	89.7↓	87.3↓	83.0↓
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	60.7↑	55.2↓	52.9↓

Барилга: Тус салбарын ерөнхий үзүүлэлтүүдийн хувьд энэ улиралд шинэ захиалга, үйлдвэрлэл, ажил эрхлэлт болон нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны индексийн утга тэлэх мужид гарсан бол бараа материалын нөөцийн индексийн утга агших мужид гарлаа. Өмнөх улиралтай харьцуулахад бараа материалын нөөцөөс бусад үзүүлэлтүүдийн индексийн утга өссөн байна /Зураг 6/.

Барилгын салбарын нэмэлт үзүүлэлтүүдийн хувьд барилга угсралтын үйл ажиллагааны индексийн утга өсч тэлэлтийн муж руу шилжсэн бол борлуулалтын үйл ажиллагааны индексийн утга буурч агших мужид шилжлээ. Түүхий эд, материалын үнийн индексийн утга 10 улирал, бизнесийн үйл ажиллагааны төлөвийн индексийн утга 3 улирал дараалан тэлэлтийн мужид гарсан байна. Харин орон сууцны зах зээлийн идэвхжил 7, худалдан авалтын тоо хэмжээ болон туслан гүйцэтгэгч ашиглалтын индексийн утга тус бүр 10 улирал дараалан агших мужид гарчээ /Хүснэгт 2/.

Дотоод худалдаа: Салбарын ерөнхий үзүүлэлтүүдийн хувьд 2023 оны II улиралд шинэ захиалга, үйлдвэрлэл (борлуулалт) болон бараа материалын нөөцийн индексийн утга тэлэлтийн мужид гарсан бол ажил эрхлэлт, нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны индексийн утга агших мужид гарлаа. Өмнөх улиралтай харьцуулахад үйлдвэрлэлийн индексийн утга өссөн бол бусад үзүүлэлтүүдийн индексийн утга буурсан байна /Зураг 7/.


Зураг 6. Барилгын салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр



Хүснэгт 2. Барилгын салбарын нэмэлт үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2022.IV	2023.I	2023.II
Худалдан авалтын тоо хэмжээ	28.0↓	40.0↑	45.7↑
Түүхий эд, материалын үнэ	91.7↓	95.6↑	81.9↓
Орон сууцны зах зээлийн идэвхжил	22.1↓	42.4↑	46.3↑
Борлуулалтын үйл ажиллагаа	25.0↓	74.6↑	43.8↓
Барилга, угсралтын үйл ажиллагаа	23.1↓	37.2↑	54.3↑
Туслан гүйцэтгэгч ашиглалт	34.6↓	49.3↑	49.7↑
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	57.1↑	58.2↑	56.8↓

Зураг 7. Дотоод худалдааны салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр



Дотоод худалдааны салбарын нэмэлт үзүүлэлтүүдийн хувьд түүхий эд, материалын үнэ болон худалдан авсан барааны хэмжээний индексийн утга тус бүр 10 улирал дараалан тэлэлтийн мужид гарсан бол хүлээгдэж буй борлуулалт 4 улирал дараалан агших мужид гарлаа. Өмнөх улиралтай харьцуулахад түүхий эд, материалын үнэ болон худалдан авсан барааны хэмжээний индексийн утга буурсан бол хүлээгдэж буй борлуулалтын индексийн утга өссөн байна /Хүснэгт 3/.


Үйлчилгээ: Салбарын ерөнхий үзүүлэлтүүдийн хувьд тайлант улиралд нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа агших мужид гарсан бол ажил эрхлэлт, үйлдвэрлэл, шинэ захиалгын индексийн утга тэлэлтийн мужид гарлаа. Үзүүлэлтүүдийг өмнөх улиралтай харьцуулахад шинэ захиалга, үйлдвэрлэл болон ажил эрхлэлтийн индексийн утга буурсан бол нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны индексийн утга өссөн байна /Зураг 8/.

Тус салбарын нэмэлт үзүүлэлтүүдийн хувьд түүхий эд, материалын үнийн индексийн утга 10, үйлчилгээний үнийн индексийн утга 8, бизнесийн үйл ажиллагааны төлөвийн индексийн утга 3 улирал дараалан тэлэлтийн мужид гарчээ. Харин дуусаагүй ажил үйлчилгээний индекс агших мужаас тэлэх мужид шилжсэн байна. Үйлчилгээний үнэ, бизнесийн үйл ажиллагааны төлөвийн индексийн утга өмнөх улиралтай харьцуулахад буурсан бол бусад үзүүлэлтүүдийн индексийн утга өссөн үзүүлэлттэй байна /Хүснэгт 4/.

Хүснэгт 3. Дотоод худалдааны салбарын нэмэлт үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2022.IV	2023.I	2023.II
Түүхий эд, материалын үнэ	86.4↓	72.8↓	67.0↓
Худалдан авсан барааны хэмжээ	77.7↓	83.8↑	62.5↓
Хүлээгдэж буй борлуулалт	47.4↓	36.9↓	45.2↑

Зураг 8. Үйлчилгээний салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр



Хүснэгт 4. Үйлчилгээний салбарын нэмэлт үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2022.IV	2023.I	2023.II
Түүхий эд, материалын үнэ	84.4↓	83.0↓	85.4↑
Үйлчилгээний үнэ	62.8↓	71.1↑	70.8↓
Дуусаагүй ажил үйлчилгээ	56.1↑	47.4↓	71.3↑
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	56.6↑	73.1↑	55.8↓


3. ААН-ийн ажиллагсдын тооны бүлгээр

Ажиллагсдын тооны бүлэг: Аж ахуйн нэгжүүдийг ажилчдын тоогоор жижиг (50 хүртэл), дунд (50-199), том (200-с дээш) гэж ангилан тайлант улирлын худалдан авалтын менежерийн индексийн утгыг тооцвол том ААН-үүдийн индексийн утга 5 улирал, дунд ААН-үүдийн индексийн утга 2 улирал дараалан тэлэлтийн мужид гарсан бол жижиг ААН-үүдийн индексийн утга 10 улирал дараалан агших мужид гарч байна. Харин индексийн утгыг өмнөх улиралтай харьцуулахад жижиг ААН-үүд 3.2 нэгж хувиар, дунд ААН-үүд 1.7 нэгж хувиар, том ААН-үүд 1.5 нэгж хувиар тус бүр өсөж, харгалзан 48.0%, 53.9%, 58.4%-тай гарлаа /Зураг 9/.


Жижиг: ААН-үүдийн хувьд шинэ захиалга, ажил эрхлэлт болон бараа материалын нөөцийн үзүүлэлтүүдийн индексийн утга агших мужид гарсан бол үйлдвэрлэл болон нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны индексийн утга тэлэлтийн мужид гарлаа. Өмнөх улиралтай харьцуулахад ажил эрхлэлт болон бараа материалын нөөцийн индексийн утга буурсан бол бусад үзүүлэлтүүдийн индексийн утга өссөн дүр зурагтай байна /Зураг 10/.

Дунд: ААН-үүдийн хувьд шинэ захиалга, үйлдвэрлэл болон бараа материалын нөөцийн индексийн утга тэлэлтийн мужид гарсан бол нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа болон ажил эрхлэлтийн индексийн утга агших мужид гарлаа. Үзүүлэлтүүдийг өмнөх улиралтай харьцуулахад нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа болон ажил эрхлэлтийн индексийн утга буурсан бол бусад үзүүлэлтийн индексийн утга өссөн байна /Зураг 11/.


Зураг 9. Байгууллагын хэмжээгээр



Зураг 10. Жижиг ААН-үүд, үзүүлэлтүүдээр




Зураг 11. Дунд ААН-үүд үзүүлэлтүүдээр




Том: Том ААН-үүдийн хувьд ажил эрхлэлт, шинэ захиалга болон бараа материалын нөөцийн индексийн утга тэлэлтийн мужид гарлаа. Харин нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны индексийн утга 10 улирал дараалан агших мужид гарсан байна. Үзүүлэлтүүдийг өмнөх улиралтай харьцуулахад шинэ захиалга, үйлдвэрлэл болон бараа материалын нөөцийн индексийн утга өссөн бол бусад үзүүлэлтүүдийн индексийн утга буурчээ /Зураг 12/.

Зураг 12. Том ААН-үүд үзүүлэлтүүдээр



4. Олон улсын PMI индекс

Зураг 13. Монгол болон худалдааны голлох түнш улсуудын PMI



Худалдааны голлох түнш улсуудын PMI¹: 2023 оны II улиралд² худалдааны голлох түнш улсуудын нэг болох АНУ болон дэлхийн ерөнхий индекс өмнөх улирлаас өсөж тэлэлтийн мужид гарлаа. БНХАУ, ОХУ болон Евро бүсийн ерөнхий индексийн утга буурсан ч тэлэлтийн мужид хэвээр байна. БНХАУ-ын бизнесийн идэвхжил 2023 оны 5 дугаар сар хүртэл хурдацтай явагдаж байсан бол 6 дугаар сард аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн өсөлт буурсан нь нийт индексийн утга буурахад голлон нөлөөлсөн байна. ОХУ-ын аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2023 оны 6 дугаар сард үргэлжлүүлэн өсөх хандлагатай байна. Гэхдээ түүхий эд, материалын нийлүүлэлт тасалдаж, үнэ өссөн нь индексийн утга өмнөх улирлаас буурахад нөлөөлжээ. Евро бүсийн хувьд индексийн утга он гарснаас хойш хамгийн доод түвшинд хүрээнд байна. Шинэ захиалгын индекс нэгдүгээр сараас хойш анх удаа буурч, ажил эрхлэлтийн өсөлт

¹ Голлох түнш улсуудын PMI индексийн сарын үзүүлэлтийг дундажлан тооцсон болно.

² 2023 оны 1, 2 болон 3 дугаар сарын үзүүлэлтийг дунджилсан болно.

удааширч, үйлдвэрлэлийн өсөлт мөн буурах хүлээлттэй байна. АНУ-ын компаниудын бизнесийн үйл ажиллагаа эхний хагас жилийн байдлаар нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд нэгдсэн индексийн утга өсөхөд шинэ захиалгын индекс өссөн нь голлон нөлөөлжээ. Дэлхийн PMI индекс өсөхөд үйлчилгээний салбарын үйл ажиллагаа нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн бөгөөд компаниудын шинэ захиалгын хэмжээ өссөнөөр бизнесийн үйл ажиллагааг идэвхжүүлсэн байна /Зураг 13/.

5. Хавсралт

ААН-ийн ерөнхий мэдээлэл

Судалгааны түүвэрлэлт хийхдээ аж үйлдвэр, барилга, дотоод худалдаа (бөөний болон жижиглэн) болон үйлчилгээний салбаруудаас идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй, эх олонлогийг төлөөлөхүйц 500 орчим ААН-үүдийг **жижиг** (49 хүртэл ажилтантай), **дунд** (50-199 хүртэл ажилтантай), **том** (200-с дээш ажилтантай) гэж ангилан түүвэрлэлт хийсэн бөгөөд ингэхдээ тухайн ангилалд хамаарах бүх аж ахуйн нэгжүүдээс жилийн борлуулалтын орлогоор тэргүүлэх аж ахуйн нэгжүүдийг түүвэрт сонголоо.

Санал асуулгыг **2023 оны II улиралд нийт 512** аж ахуйн нэгжийн дунд явуулсан бөгөөд **аж үйлдвэрийн салбарын 123, барилгын салбарын 114, дотоод худалдааны салбарын 72, үйлчилгээний салбарын 203** аж ахуйн нэгж судалгаанд хамрагдлаа. Ажилчдын тоогоор жижиг ангилалд хамаарах 352 (69%), дунд 109 (21%), том 51 (10%) аж ахуйн нэгжүүд судалгаанд оролцлоо /Хүснэгт 1/.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн тоо, салбар, ажилтны тооны бүлгээр³

Ерөнхий салбар	Салбар	ААН-ийн тоо 2023.1*	Жижиг	Дунд	Том	Нийт	Эзлэх хувь
Аж үйлдвэр (123)	Уул уурхай, олборлолт	944	6	4	5	15	3%
	Боловсруулах үйлдвэрлэл	6,068	61	19	9	89	17%
	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	265	7	3	2	12	2%
	Усан хангамж	228	2	4	1	7	1%
Барилга	Барилга	7,252	82	26	6	114	22%
Дотоод худалдаа	Бөөний болон жижиглэн худалдаа	33,485	52	13	7	72	14%
Үйлчилгээ (203)	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2,886	10	3	3	16	3%
	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажилл	2,575	7	4	1	12	2%
	Мэдээлэл, холбоо	2,544	10	3	1	14	3%
	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1,919	10	7	2	19	4%
	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1,166	4	2	1	7	1%
	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн ү.а	5,580	5			5	1%
	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	3,793	2			2	0%
	Боловсрол	3,630	5	4	1	10	2%
	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	2,494	10	3	4	17	3%
	Урлаг, үзвэр, тоглоом наадам	973	2		1	3	1%
	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	6,902	77	14	7	98	19%
Нийт		82,704	352	109	51	512	100%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

³ 2023 оны I улирлын байдлаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн тоо,

Жилийн борлуулалтын орлогоор ангилан авч үзвэл 50 хүртэл сая төгрөгийн 41 (8%), 50-300 сая төгрөгийн 47 (9%), 300 саяас 1 тэрбум төгрөгийн 86 (17%), 1-2.5 тэрбум төгрөгийн 98 (19%), 2.5-с дээш тэрбум төгрөгийн орлоготой 239 (47%) аж ахуйн нэгж судалгаанд хамрагджээ /Хүснэгт 2/.

Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн тоо, салбар, жилийн борлуулалтын орлогын бүлгээр

Ерөнхий салбар	Салбар	Жижиг	Дунд	Том	Нийт	Эзлэх хувь
Аж үйлдвэр	50 сая₮ хүртэл	9			9	2%
	50-300 сая₮ хүртэл	13			13	3%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	18	3		21	4%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	19	2	1	22	4%
	2.5 тэрбум₮ дээш	17	25	16	58	11%
Барилга	50 сая₮ хүртэл	9			9	2%
	50-300 сая₮ хүртэл	8			8	2%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	14			14	3%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	22	4		26	5%
	2.5 тэрбум₮ дээш	29	22	6	57	11%
Дотоод худалдаа	50 сая₮ хүртэл	5			5	1%
	50-300 сая₮ хүртэл	4			4	1%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	7			7	1%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	8			8	2%
	2.5 тэрбум₮ дээш	28	13	7	48	9%
Үйлчилгээ	50 сая₮ хүртэл	18		1	19	4%
	50-300 сая₮ хүртэл	22			22	4%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	42	1	1	44	9%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	33	8	1	42	8%
	2.5 тэрбум₮ дээш	27	31	18	76	15%
Нийт	50 сая₮ хүртэл	41	-		41	8%
	50-300 сая₮ хүртэл	47	-		47	9%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	81	4	1	86	17%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	82	14	2	98	19%
	2.5 тэрбум₮ дээш	101	91	47	239	47%
Нийт		352	109	51	512	100%

Худалдан авалтын менежерийн индексийн тухай

Худалдан авалтын менежерийн индекс (PMI) нь бодлого боловсруулагчид, хөрөнгө оруулагчид болон аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудын хувьд эдийн засаг, бизнесийн төлөв байдлыг харах, үйл ажиллагаагаа удирдах, төлөвлөх, урьдчилан таамаглах, шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой үзүүлэлт болдог. PMI нь тооцоход хялбар энгийн аргачлал дээр үндэслэгдэж, албан ёсны статистик тоон мэдээлэл гарахаас өмнө эдийн засаг, бизнесийн төлөв байдлыг тодорхойлохын зэрэгцээ бусад орнуудтай харьцуулалт хийх боломж олгодгоороо давуу талтай. Олон улсын туршлагаас харахад уг индексийг тооцохдоо эдийн засгийн голлох салбаруудын нөлөө бүхий 400 орчим аж ахуйн нэгжүүдийг сонгон түүвэрлэлтэд хамруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, шинэ захиалга, ажил эрхлэлт, бараа материалын нөөц, хүргэлтийн хугацаа болон бусад үзүүлэлтийн талаарх мэдээллийг судалж, эдгээр үзүүлэлт бүрээр индексийн утгыг тооцон, индексийн өөрчлөлтийг харгалзан дүгнэлт өгдөг.

“Худалдан авалтын менежерийн индекс (Purchasing manager index-PMI)” нь эдийн засгийн ерөнхий хандлагыг харуулсан чиглэлийн индекс юм.

Аргачлал: Түүвэр судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдээс үзүүлэлт тус бүрийн хувьд өмнөх улирлаас хэрхэн өөрчлөгдсөн талаар чанарын асуулт асууж, хариултуудыг нэгтгэх замаар тоон буюу индексийн утгад шилжүүлнэ. Индексийг үзүүлэлт тус бүрээр тооцон гаргаж салбаруудын индекс, нийлмэл индекс, нийт эдийн засгийн индексийг тооцоолоход ашиглана.

$$\text{PMI (тухайн үзүүлэлтийн тархалтын индекс)} = (K1 * 1) + (K2 * 0.5) + (K3 * 0)$$

$k1$ = Өссөн гэсэн хариултын хувь

$k2$ = Хэвэндээ гэсэн хариултын хувь

$k3$ = Буурсан гэсэн хариултын хувь

Уг индексийн тооцоолсон утгыг **тархалтын индекс** гэж нэрлэх бөгөөд PMI=50 бол бизнесийн үйл ажиллагаанд өөрчлөлт ороогүйг, PMI>50 бол бизнесийн үйл ажиллагааны тэлэлтийг, PMI<50 бол агшилтыг тус тус илэрхийлдэг. Энэхүү утга 50-аас холдох тусам тэлэлт эсвэл агшилт ихэснэ. Тодруулбал, PMI-ийн үзүүлэлт өмнөх улирлын үзүүлэлтээс өндөр байвал эдийн засаг илүү хурдтай тэлж (агшиж) байгааг, харин өмнөх улирлаас доогуур байвал илүү багаар тэлж (агшиж) байна гэсэн утгыг илэрхийлнэ.

Энэхүү судалгаанд PMI-ийг эдийн засгийн голлох салбаруудаар тооцохын зэрэгцээ аж ахуйн нэгжийн ажилчдын тоог нь харгалзан жижиг (49 хүртэл), дунд (50-199), том (200-с дээш) гэж ангилан, бүлэг тус бүрээр индексийг тооцож гаргасан. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлогын нийт борлуулалтын орлогод эзлэх хувиар нь бүлэг тус бүрийн үзүүлэлтийн тархалтын индексийг жигнэж тухайн үзүүлэлтийн салбар бүр дэх индексийн утгыг тооцлоо. Салбар болон нийт эдийн засгийн PMI-ийг тооцохдоо гол үзүүлэлтүүдийн нийлмэл⁴ индексийг олон улсад нийтлэг ашиглагддаг ач холбогдлын жингээр⁵ жигнэн тооцсон болно.

⁴ Салбар бүр дэх гол 5 үзүүлэлтүүдийн индексийг ДНБ-д эзлэх хувиар жигнэн тооцсон үзүүлэлт болно.

⁵ Олон улсын туршлагаар PMI-ийг тооцохдоо шинэ захиалга 30%, үйлдвэрлэлийн хэмжээ 25%, ажил эрхлэлт 20%, нийлүүлэлт хугацаа 15%, бараа материалын нөөц 10%-иар жигнэж тооцдог байна. An introduction to the PMI surveys, HIS Markit/.

Аж үйлдвэр

Үзүүлэлт	2021.I	2021.II	2021.III	2021.IV	2022.I	2022.II	2022.III	2022.IV	2023.I	2023.II
Аж үйлдвэр	40.0%	40.9%	54.9%	52.1%	41.6%	56.2%	52.9%	59.8%	54.2%	59.0%
Шинэ захиалга	36.3%	40.5%	66.6%	62.4%	47.9%	60.1%	61.6%	66.0%	47.9%	62.6%
Үйлдвэрлэл	36.1%	40.8%	61.7%	61.0%	43.5%	56.8%	56.6%	63.6%	55.0%	65.9%
Ажил эрхлэлт	53.9%	45.1%	57.7%	58.5%	63.3%	60.6%	52.3%	71.8%	59.3%	53.6%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	37.2%	31.2%	23.3%	14.1%	10.6%	37.3%	35.8%	45.6%	54.2%	44.8%
Түүхий эд, материалын нөөц	37.3%	48.9%	45.1%	42.8%	21.4%	62.9%	44.5%	29.2%	61.0%	63.4%
Жижиг										
Шинэ захиалга	34.8%	38.6%	48.9%	44.9%	30.7%	32.8%	37.2%	38.6%	41.1%	52.1%
Үйлдвэрлэл	32.0%	38.6%	46.6%	35.2%	29.5%	34.5%	38.6%	44.7%	42.1%	49.3%
Ажил эрхлэлт	50.0%	43.2%	43.2%	48.9%	43.8%	40.8%	41.6%	45.2%	41.4%	39.7%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	40.4%	49.4%	42.6%	43.8%	25.0%	50.0%	42.6%	48.1%	52.6%	58.8%
Түүхий эд, материалын нөөц	38.8%	33.5%	43.8%	39.8%	34.1%	35.6%	29.6%	36.7%	42.0%	43.1%
Дуусаагүй үйлдвэрлэл	40.4%	43.2%	47.7%	46.0%	32.4%	50.0%	57.2%	48.7%	51.3%	54.4%
Бэлэн бүтээгдэхүүн	36.0%	40.3%	44.9%	43.2%	32.4%	37.9%	34.1%	42.6%	43.9%	50.0%
Бүтээгдэхүүний үнэ	65.2%	65.3%	64.2%	73.3%	66.5%	83.3%	70.4%	78.3%	72.2%	69.1%
Худалдан авалтын тоо хэмжээ	44.9%	54.0%	61.4%	46.0%	51.1%	34.5%	40.4%	36.1%	39.9%	46.7%
Түүхий эд, материалын үнэ	86.5%	88.6%	85.2%	85.2%	84.1%	92.5%	89.2%	90.7%	85.8%	84.5%
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	59.6%	57.4%	61.4%	46.0%	58.5%	55.1%	36.5%	63.8%	57.1%	51.5%
Дунд										
Шинэ захиалга	37.0%	48.0%	44.0%	50.0%	30.0%	50.0%	50.0%	52.0%	51.0%	53.4%
Үйлдвэрлэл	37.0%	52.0%	38.0%	40.0%	32.0%	52.0%	48.1%	63.0%	53.9%	62.1%
Ажил эрхлэлт	50.0%	48.0%	46.0%	50.0%	52.0%	50.0%	42.3%	48.1%	52.9%	43.1%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	43.5%	26.0%	42.0%	32.0%	12.0%	38.0%	38.5%	48.0%	43.9%	43.1%
Түүхий эд, материалын нөөц	47.8%	52.0%	48.0%	20.0%	32.0%	42.0%	44.0%	35.2%	50.0%	59.1%
Дуусаагүй үйлдвэрлэл	41.3%	56.0%	58.0%	48.0%	48.0%	60.0%	58.3%	55.8%	46.7%	62.1%
Бэлэн бүтээгдэхүүн	50.0%	56.0%	60.0%	48.0%	48.0%	44.0%	47.9%	46.3%	55.1%	52.3%
Бүтээгдэхүүний үнэ	58.7%	66.0%	68.0%	64.0%	76.0%	88.0%	78.8%	73.1%	79.4%	71.7%
Худалдан авалтын тоо хэмжээ	56.5%	60.0%	50.0%	56.0%	50.0%	56.0%	47.7%	51.9%	50.0%	47.8%
Түүхий эд, материалын үнэ	82.6%	86.0%	90.0%	84.0%	88.0%	92.0%	88.0%	94.2%	93.0%	86.7%
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	56.5%	54.0%	60.0%	60.0%	52.0%	45.5%	36.4%	69.6%	63.0%	52.2%
Том										
Шинэ захиалга	36.4%	40.0%	70.0%	65.0%	50.0%	63.6%	65.0%	70.0%	47.9%	64.7%
Үйлдвэрлэл	36.4%	40.0%	65.0%	65.0%	45.0%	59.1%	59.1%	65.0%	56.0%	67.6%
Ажил эрхлэлт	54.5%	45.0%	60.0%	60.0%	65.0%	63.6%	54.5%	77.3%	61.5%	56.3%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	36.4%	30.0%	20.0%	10.0%	10.0%	36.4%	35.0%	45.0%	56.0%	44.1%
Түүхий эд, материалын нөөц	36.4%	50.0%	45.0%	45.0%	20.0%	68.2%	45.5%	27.8%	64.0%	65.4%
Дуусаагүй үйлдвэрлэл	36.4%	40.0%	50.0%	55.0%	40.0%	59.1%	65.0%	50.0%	52.2%	64.7%
Бэлэн бүтээгдэхүүн	54.5%	55.0%	35.0%	60.0%	40.0%	68.2%	54.5%	33.3%	65.4%	61.5%
Бүтээгдэхүүний үнэ	72.7%	55.0%	80.0%	80.0%	75.0%	86.4%	85.0%	68.2%	80.0%	61.8%
Худалдан авалтын тоо хэмжээ	27.3%	50.0%	45.0%	65.0%	60.0%	77.3%	70.0%	60.0%	53.8%	53.6%
Түүхий эд, материалын үнэ	86.4%	75.0%	95.0%	100.0%	100.0%	81.8%	95.0%	88.9%	86.5%	82.4%
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	63.6%	60.0%	65.0%	85.0%	65.0%	83.3%	38.9%	59.1%	53.8%	53.1%

Барилга

Үзүүлэлт	2021.I	2021.II	2021.III	2021.IV	2022.I	2022.II	2022.III	2022.IV	2023.I	2023.II
Барилга	29.9%	38.7%	36.5%	31.4%	38.0%	36.3%	36.4%	29.7%	44.5%	53.7%
Шинэ захиалга	25.7%	43.3%	44.7%	32.9%	37.0%	30.7%	34.1%	21.0%	35.4%	54.4%
Үйлдвэрлэл	23.3%	39.0%	39.0%	33.6%	32.8%	35.6%	35.7%	26.8%	40.8%	51.2%
Ажил эрхлэлт	43.2%	47.1%	40.9%	35.8%	47.1%	37.8%	38.8%	30.4%	59.3%	61.2%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	34.4%	23.8%	19.2%	28.7%	43.7%	58.4%	49.4%	58.7%	48.4%	51.7%
Түүхий эд, материалын нөөц	25.8%	29.3%	23.2%	16.2%	27.0%	18.6%	21.0%	17.8%	45.0%	45.4%
Жижиг										
Шинэ захиалга	25.6%	35.0%	42.5%	35.0%	33.3%	27.8%	28.6%	25.6%	39.3%	40.9%
Үйлдвэрлэл	22.2%	31.3%	42.5%	36.3%	29.8%	30.0%	31.0%	26.1%	47.5%	43.4%
Ажил эрхлэлт	43.3%	47.5%	45.0%	41.3%	44.0%	36.7%	34.3%	31.6%	41.1%	34.8%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	41.1%	37.5%	26.3%	28.8%	46.4%	53.3%	59.6%	62.0%	54.5%	52.8%
Түүхий эд, материалын нөөц	25.6%	27.5%	32.5%	25.0%	20.2%	12.2%	22.5%	21.9%	38.6%	35.4%
Худалдан авалтын тоо хэмжээ	22.2%	40.0%	45.0%	31.3%	35.7%	42.2%	37.8%	32.6%	42.2%	38.6%
Түүхий эд, материалын үнэ	92.2%	93.8%	91.3%	87.5%	82.1%	90.0%	92.9%	93.8%	89.8%	88.1%
Орон сууцны зах зээлийн идэвхжил	24.3%	45.5%	58.3%	48.6%	47.6%	43.3%	36.4%	21.1%	33.3%	43.1%
Борлуулалтын үйл ажиллагаа	14.4%	40.0%	42.5%	40.0%	33.3%	37.8%	34.8%	27.3%	67.8%	37.7%
Барилга, угсралтын үйл ажиллагаа	16.7%	45.0%	41.3%	36.3%	34.5%	38.9%	38.5%	25.6%	41.2%	40.8%
Туслан гүйцэтгэгч ашиглалт	43.3%	48.8%	40.0%	37.5%	45.2%	41.1%	47.7%	44.3%	47.1%	46.9%
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	77.8%	60.0%	26.3%	45.0%	75.0%	43.5%	36.9%	57.3%	53.3%	56.4%
Дунд										
Шинэ захиалга	30.5%	50.0%	44.4%	22.2%	34.4%	31.0%	27.6%	22.9%	42.9%	56.3%
Үйлдвэрлэл	26.8%	38.9%	34.4%	25.6%	32.2%	32.1%	36.9%	27.9%	50.0%	44.0%
Ажил эрхлэлт	47.6%	46.7%	38.9%	37.8%	43.3%	35.7%	33.3%	24.3%	62.0%	48.1%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	28.0%	22.2%	17.8%	34.4%	40.0%	58.3%	70.3%	62.5%	54.0%	54.0%
Түүхий эд, материалын нөөц	25.6%	28.9%	22.2%	11.1%	23.3%	9.5%	17.1%	16.2%	56.0%	45.8%
Худалдан авалтын тоо хэмжээ	26.8%	46.7%	38.9%	17.8%	41.1%	42.9%	30.3%	27.9%	52.0%	43.8%
Түүхий эд, материалын үнэ	91.5%	90.0%	94.4%	91.1%	85.6%	88.1%	93.8%	94.6%	92.0%	90.4%
Орон сууцны зах зээлийн идэвхжил	38.9%	52.6%	55.4%	37.2%	51.1%	44.0%	33.9%	34.6%	35.3%	41.7%
Борлуулалтын үйл ажиллагаа	29.3%	40.0%	42.2%	26.7%	34.4%	26.2%	32.1%	26.6%	73.1%	36.7%
Барилга, угсралтын үйл ажиллагаа	28.0%	51.1%	46.7%	21.1%	32.2%	34.5%	26.9%	25.8%	58.8%	41.7%
Туслан гүйцэтгэгч ашиглалт	43.9%	53.3%	46.7%	25.6%	47.8%	45.2%	37.1%	27.6%	50.0%	30.8%
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	72.0%	62.2%	30.0%	41.1%	68.9%	42.4%	27.6%	63.0%	53.8%	54.0%
Том										
Шинэ захиалга	16.1%	43.1%	45.8%	38.9%	41.2%	32.4%	41.4%	17.9%	30.0%	60.0%
Үйлдвэрлэл	17.9%	43.1%	40.3%	37.5%	35.3%	41.2%	37.9%	26.7%	33.3%	58.3%
Ажил эрхлэлт	33.9%	47.2%	40.3%	31.9%	51.5%	39.7%	44.8%	32.8%	66.7%	80.0%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	35.7%	18.1%	16.7%	25.0%	44.1%	61.8%	30.8%	55.4%	42.9%	50.0%
Түүхий эд, материалын нөөц	26.8%	30.6%	19.4%	15.3%	33.8%	27.9%	22.4%	16.7%	42.9%	50.0%
Худалдан авалтын тоо хэмжээ	21.4%	51.4%	38.9%	22.2%	44.1%	42.6%	36.5%	25.9%	33.3%	50.0%
Түүхий эд, материалын үнэ	78.6%	100.0%	98.6%	81.9%	79.4%	79.4%	96.6%	89.3%	100.0%	75.0%
Орон сууцны зах зээлийн идэвхжил	28.0%	53.6%	55.4%	37.1%	41.2%	42.6%	47.7%	16.7%	50.0%	50.0%
Борлуулалтын үйл ажиллагаа	14.3%	40.3%	47.2%	36.1%	42.6%	39.7%	53.8%	23.2%	78.6%	50.0%
Барилга, угсралтын үйл ажиллагаа	25.0%	44.4%	54.2%	34.7%	41.2%	36.8%	39.7%	20.7%	25.0%	66.7%
Туслан гүйцэтгэгч ашиглалт	37.5%	44.4%	48.6%	33.3%	48.5%	48.5%	53.8%	33.3%	50.0%	60.0%
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	69.6%	66.7%	36.1%	50.0%	58.8%	53.1%	41.1%	54.2%	62.5%	58.3%

Дотоодын худалдаа

Үзүүлэлт	2021.I	2021.II	2021.III	2021.IV	2022.I	2022.II	2022.III	2022.IV	2023.I	2023.II
Дотоод худалдаа	33.1%	36.4%	43.3%	45.7%	33.5%	46.4%	37.7%	41.0%	56.0%	52.9%
Шинэ захиалга	22.7%	31.4%	42.5%	46.5%	39.1%	45.4%	34.8%	44.8%	54.1%	54.3%
Үйлдвэрлэл	29.1%	36.2%	47.3%	52.6%	23.7%	50.8%	37.1%	27.8%	68.1%	72.5%
Ажил эрхлэлт	47.8%	44.7%	49.6%	51.6%	47.8%	49.2%	43.3%	44.7%	53.7%	41.3%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	42.1%	35.8%	36.4%	29.7%	19.7%	43.6%	35.2%	43.6%	42.4%	32.1%
Түүхий эд, материалын нөөц	31.1%	36.4%	33.7%	37.9%	33.1%	36.4%	40.7%	51.1%	56.4%	53.8%
Жижиг										
Шинэ захиалга	21.1%	32.6%	40.0%	34.2%	38.9%	42.6%	32.6%	37.6%	46.5%	45.8%
Үйлдвэрлэл	23.7%	33.7%	45.8%	42.1%	26.8%	44.2%	32.8%	19.2%	50.7%	54.3%
Ажил эрхлэлт	43.2%	41.6%	47.4%	47.4%	45.8%	44.2%	43.0%	38.8%	40.8%	39.6%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	46.8%	40.5%	32.1%	32.6%	21.1%	42.1%	41.8%	45.6%	46.9%	45.7%
Түүхий эд, материалын нөөц	34.2%	32.6%	30.5%	28.9%	33.2%	37.4%	44.4%	50.0%	44.8%	40.7%
Худалдан авсан барааны дундаж үнэ	70.5%	71.1%	79.5%	82.1%	82.1%	79.5%	83.5%	90.4%	81.9%	79.2%
Худалдан авсан барааны хэмжээ	55.3%	54.7%	63.7%	58.9%	69.5%	75.3%	80.8%	82.1%	88.4%	54.3%
Хүлээгдэж буй борлуулалт	11.1%	19.5%	17.9%	24.2%	20.0%	61.1%	41.5%	50.0%	26.3%	33.0%
Дунд										
Шинэ захиалга	21.9%	31.3%	43.8%	50.0%	37.5%	40.6%	38.2%	39.5%	54.5%	53.8%
Үйлдвэрлэл	31.3%	34.4%	59.4%	53.1%	37.5%	56.3%	41.7%	22.7%	69.2%	59.1%
Ажил эрхлэлт	43.8%	40.6%	56.3%	56.3%	59.4%	46.9%	44.7%	47.4%	65.4%	42.3%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	31.3%	21.9%	12.5%	18.8%	15.6%	43.8%	31.6%	26.3%	50.0%	31.8%
Түүхий эд, материалын нөөц	37.5%	25.0%	40.6%	62.5%	40.6%	25.0%	44.7%	55.6%	62.5%	62.5%
Худалдан авсан барааны дундаж үнэ	75.0%	71.9%	90.6%	96.9%	90.6%	84.4%	84.2%	94.7%	72.7%	73.1%
Худалдан авсан барааны хэмжээ	53.1%	62.5%	78.1%	68.8%	68.8%	87.5%	85.3%	89.5%	90.9%	77.3%
Хүлээгдэж буй борлуулалт	18.8%	12.5%	18.8%	31.3%	15.6%	66.7%	39.5%	52.8%	34.6%	34.6%
Том										
Шинэ захиалга	25.0%	30.0%	45.0%	60.0%	40.0%	50.0%	35.7%	55.6%	62.5%	64.3%
Үйлдвэрлэл	35.0%	40.0%	45.0%	65.0%	15.0%	55.0%	40.0%	40.0%	87.5%	100.0%
Ажил эрхлэлт	55.0%	50.0%	50.0%	55.0%	45.0%	55.0%	42.9%	50.0%	62.5%	42.9%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	40.0%	35.0%	50.0%	30.0%	20.0%	45.0%	28.6%	50.0%	33.3%	16.7%
Түүхий эд, материалын нөөц	25.0%	45.0%	35.0%	40.0%	30.0%	40.0%	33.3%	50.0%	66.7%	64.3%
Худалдан авсан барааны дундаж үнэ	75.0%	85.0%	65.0%	85.0%	75.0%	75.0%	92.9%	77.8%	62.5%	50.0%
Худалдан авсан барааны хэмжээ	55.0%	65.0%	65.0%	70.0%	60.0%	80.0%	83.3%	66.7%	75.0%	64.3%
Хүлээгдэж буй борлуулалт	20.0%	30.0%	30.0%	45.0%	20.0%	42.9%	64.3%	41.7%	50.0%	64.3%

Үйлчилгээ

Үзүүлэлт	2021.I	2021.II	2021.III	2021.IV	2022.I	2022.II	2022.III	2022.IV	2023.I	2023.II
Үйлчилгээ	31.0%	40.4%	41.0%	42.2%	44.1%	55.3%	51.2%	51.3%	54.8%	53.5%
Шинэ захиалга	30.3%	38.9%	42.9%	41.3%	43.5%	56.0%	47.5%	51.6%	52.2%	54.0%
Борлуулалтын орлого	28.4%	42.2%	45.6%	48.5%	49.0%	53.4%	55.7%	50.4%	66.2%	59.0%
Ажил эрхлэлт	39.1%	51.1%	47.7%	54.0%	53.7%	63.0%	53.9%	52.1%	58.9%	51.7%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	26.2%	26.5%	21.5%	18.6%	25.1%	47.0%	47.4%	51.3%	36.5%	46.4%
Жижиг										
Шинэ захиалга	18.2%	33.3%	45.8%	45.2%	39.3%	45.2%	40.4%	38.5%	46.2%	49.6%
Борлуулалтын орлого	17.5%	35.7%	47.0%	48.8%	41.7%	48.2%	44.6%	43.4%	50.0%	52.9%
Ажил эрхлэлт	43.5%	46.4%	39.3%	48.2%	50.6%	48.8%	48.8%	42.2%	40.1%	42.5%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	39.6%	29.8%	29.8%	20.8%	19.6%	45.8%	42.4%	52.1%	51.4%	49.2%
Түүхий эд, материалын үнэ	76.6%	83.9%	88.1%	92.9%	89.3%	83.9%	89.0%	92.5%	85.0%	87.3%
Үйлчилгээний үнэ	43.5%	50.0%	53.0%	57.7%	56.5%	72.0%	67.5%	70.6%	68.5%	68.1%
Дуусаагүй ажил үйлчилгээ	53.2%	62.5%	60.7%	61.9%	57.1%	56.0%	68.8%	61.0%	55.1%	72.0%
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	46.8%	53.0%	43.5%	52.4%	65.5%	53.6%	36.0%	52.5%	59.9%	51.8%
Дунд										
Шинэ захиалга	23.9%	43.1%	32.8%	32.8%	37.9%	56.7%	40.4%	53.3%	45.3%	60.3%
Борлуулалтын орлого	23.9%	43.1%	37.9%	36.2%	39.7%	60.0%	51.7%	54.8%	51.4%	60.3%
Ажил эрхлэлт	39.1%	50.0%	37.9%	48.3%	43.1%	55.0%	51.7%	54.8%	51.4%	52.6%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	26.1%	29.3%	27.6%	25.9%	19.0%	45.0%	38.9%	55.3%	59.4%	50.0%
Түүхий эд, материалын үнэ	76.1%	63.8%	79.3%	93.1%	75.9%	73.3%	81.0%	84.0%	92.2%	85.7%
Үйлчилгээний үнэ	52.2%	53.4%	50.0%	55.2%	50.0%	63.3%	53.6%	65.0%	66.7%	70.0%
Дуусаагүй ажил үйлчилгээ	60.9%	56.9%	56.9%	58.6%	62.1%	63.3%	64.3%	50.0%	53.7%	83.3%
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	39.1%	53.4%	41.4%	50.0%	63.8%	42.0%	43.1%	62.0%	65.3%	59.7%
Том										
Шинэ захиалга	35.3%	38.6%	45.5%	43.2%	45.5%	57.1%	50.0%	52.9%	55.0%	52.8%
Борлуулалтын орлого	32.4%	43.2%	47.7%	52.3%	52.3%	52.4%	57.9%	50.0%	72.7%	59.5%
Ажил эрхлэлт	38.2%	52.3%	52.3%	56.8%	56.8%	66.7%	55.0%	52.6%	63.6%	52.6%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	23.5%	25.0%	18.2%	15.9%	27.3%	47.6%	50.0%	50.0%	27.8%	45.0%
Түүхий эд, материалын үнэ	85.3%	81.8%	90.9%	86.4%	88.6%	76.2%	89.5%	83.3%	80.0%	85.0%
Үйлчилгээний үнэ	38.2%	47.7%	59.1%	59.1%	56.8%	73.8%	66.7%	61.1%	72.7%	71.4%
Дуусаагүй ажил үйлчилгээ	47.1%	54.5%	56.8%	56.8%	68.2%	50.0%	50.0%	57.1%	44.4%	67.6%
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	61.8%	70.5%	56.8%	54.5%	54.5%	53.1%	50.0%	55.6%	77.3%	55.3%